

LEGAL NEWSLETTER

2025 February №53

AKP Law Firm

Бид энэ оны 02 дугаар сард батлагдсан Хууль, онцлох УИХ-ын тогтоол болон энэ сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн хууль, тогтоол, нэмэлт өөрчлөлтийг танилцуулж байна.

I. ХУУЛЬ:

“Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хууль” нь 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр УИХ-р баталж, 2025 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс дагаж мөрдөхөөр байна.

1.1. **ХУУЛИАР ЗОХИЦУУЛАХ ЗҮЙЛ, ЗОРИЛГО**

Энэ хуулийн зорилт нь түүхэн нийслэл Хархорум хотыг сэргээн байгуулж, монгол үндэстний түүх, язгуур өв, нүүдлийн соёл иргэншлийг хамгаалах, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, байгаль орчинд ээлтэй, хүний ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн хотыг төлөвлөх, бүтээн байгуулах, түүний хөгжлийг дэмжих, эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

II. ХУУЛИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ:

УИХ-аар Татварын ерөнхий хуульд 2025 оны 01 сарын 17-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулах хууль батлагдаж, 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдөр Төрийн мэдээлэлд нийтлэгдсэн байна. Үүнд:

1. Тус хуулийн 13.4 дэх хэсэгт Татвар төлөгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, эрсдэлээс

урьдчилан сэргийлэх зорилгоор дараах мэдээллийг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага татвар төлөгчийн зөвшөөрөлгүйгээр жагсаалт хэлбэрээр албан ёсны цахим хуудсанд нийтэлж, олон нийтэд мэдээллэхээр өөрчлөн найруулсан байна.

2. Мөн хуулийн 13.5-д Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 13.4-т заасны дагуу татвар төлөгчийн мэдээллийг олон нийтэд мэдээлэхээс ажлын 10-аас доошгүй өдрийн өмнө татварын албанд бүртгэлтэй утас, цахим шуудангийн хаягаар тухайн татвар төлөгчид урьдчилан мэдэгдэж, тайлбар, санал гаргахаар өөрчлөлт орсон байна.

III. ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, ХЭЛЭЛЦЭЭР:

2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр Монгол Улсын Засгийн газар болон Бүгд найрамдах Энэтхэг улсын экспорт-импортын банк хооронд байгуулагдсан зээлийн хэлэлцээр. Тус хэлэлцээр нь Монгол улсад газрын тосны үйлдвэр барих төслийг санхүүжүүлэх зорилготой байна. Нийт 700,000,000 ам.долларын санхүүжилтийг Эксим банкнаас олгохоор тохиролцсон байна.

ALISON & KATE PARTNERS

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
5-р хороо, Pearl tower А блок 902 тоот

Web: www.akp.mn

E-mail: contact@akp.mn

Tel: 7704-1414, 9511-3680